



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 45

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус үндэслэн “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар 84.7 (наян дөрвөн сая долоон зуу) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1. “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2. “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

2.2. Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалт, худалдан авалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах.

3. “Дорноговь АЗЗА” төрийн өмчит хувьцаат компани нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаар албан даалгаврын биелэлтээр 80.6 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэсэн үнэлгээ авсан байх тул гүйцэтгэх захирал (У.Баярбилэгт)-д албан даалгаврын биелэлтийг 100 хувь хангаж ажиллах, санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн, дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

3.1. Шалгалтын тайланд дурдсан зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж ажиллах.

3.2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх;

3.3. Компанийн бараа материалын дансанд бүртгэлтэй 12 нэр төрлийн, 27 ширхэг, 40.5 сая төгрөгийн өртөгтэй үндсэн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэх, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу бэлтгэсэн 42.4 сая төгрөгийн их засварын ажлыг үндсэн хөрөнгөд капиталжуулан бүртгэх саналыг төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

132001151
3-r huraldaan.docx

3.4.2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хөрөнгийн дүн, бодит хөрөнгийн дүнгээс зөрүүтэй, биет бус хөрөнгөд элэгдэл тооцож бүртгээгүй байх тул алдаа зөрчлийг залруулж баталгаажуулан ирүүлэх;

3.5.Ажил албан тушаалдаа хариуцлагагүй хандаж алдаа зөрчил гаргасан ерөнхий нягтлан бодогч Б.Тунгалагтуяад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага тооцох;

3.6.Зам, тээврийн хөгжлийн төвөөс хүлээлгэн өгсөн үнэ, үнэлгээ тодорхойгүй, цас цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай, 2 ширхэг технологийн зориулалттай тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд үнэлж бүртгэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх;

3.7.Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил, үйлчилгээ худалдан авахгүй байх, үйл ажиллагаандаа “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2021 оны 102 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

3.8.Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

4.Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байхад анхаарч ажиллах.

5.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ


ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



Ц.Түвшинзаяа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2023 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн
45 дугаар тогтоолын хавсралт



“Дорноговь АЗЗА” өрийн өмчит компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах
арга хэмжээний жагсаалт

Д/д	Зөрчил дутагдлын утга	Мөнгөн дүн (сая төгрөгөөр)	Авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүй үндсэн хөрөнгө бэлтгэсэн.	1.8	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд хувьцаа эзэмшигчийн хөрөнгийг захиран зарцуулах.
2	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу бэлтгэсэн хөрөнгийг капиталжуулан бүртгээгүй.	42.4	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллах, хөрөнгийг үндсэн хөрөнгөд капиталжуулан бүртгэх.
3	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэн ажиллаагүй.	40.5	Журмын заалтыг хэрэгжүүлэн ажиллах, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх.
4	Байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг үнэлж бүртгээгүй.	2 ширхэг тээврийн хэрэгсэл	Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Зам тээврийн хөгжлийн төвтэй хамтран холбогдох арга хэмжээ авах.
	НИЙТ ДҮН:	84.7	(Наян дөрвөн сая долоон зуун мянган төгрөг)

-----oOo-----